

БАТЛАВ.
БСШУЯ-НЫ СУРГУУЛИЙН ӨМНӨХ,
БАГА БОЛОВСРОЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ГАНТУЛГА

БАТЛАВ.
ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ГАМШГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ГАЗРЫН ДАРГА, ХУРАНДАА
Д.БАТСАЙХАН

УХА0038 9129146

“АЮУЛГҮЙ АМЬДРАХ УХААНД” СУРАЛЦЪЯ!, ХЭВШҮҮЛЬЕ!, НӨЛӨӨЛЬЕ!”
ХҮҮХДИЙН ГАР ЗУРАГ, ЭССЭ БИЧЛЭГИЙН УРАЛДААНЫ УДИРДАМЖ

БАТЛАВ.
ХҮҮХДИЙН ТӨЛӨӨ ҮНДЭСНИЙ
ГАЗРЫН ДАРГА Э.ОДБАЯР

БАТЛАВ.
ДЭЛХИЙН ЗӨН МОНГОЛ ОЛОН
УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ЗАХИРАЛ

ДОРАНА ЖАВИЕР

ҮНДЭСЛЭЛ:

Дэлхий нийтэд түгээмэл тохиолддог аюулт үзэгдэл, ослоос манай оронд ган, зуд, цасан болон шороон шуурга, цөлжилт, аянга цахилгаан, аадар бороо, үер, объектын болон ой хээрийн түймэр, хүн, мал, амьтны гоц халдварт өвчин, усны осол, техникийн холбогдолтой осол зэрэг аюулт үзэгдэл нийтлэг тохиолддог байна.

Гамшиг онцгой байдлын үед хүүхэд эрсдэлд өртөх өндөр магадлалтай эмзэг бүлэгт багтах бөгөөд тэдний аюулгүй байдлыг хангах, суралцах аюулгүй орчныг бүрдүүлэх асуудал нэн чухал юм. Дэлхийн хэмжээнд сүүлийн 35 жилд 21.000 орчим сурагчид сургууль дээрээ амь насаа алдаж, газар хөдлөлтийн улмаас 100 гаруй сургууль нурж сүйрэн, хагас сая гаруй хүүхдүүд сургуульдаа явах боломжгүй болсон тоо баримт байдаг. Тиймээс хүүхдэд чиглэсэн гамшгийн эрсдлийг бууруулах, багш ажилчдын чадавхижуулах зорилгоор “Сургуулийн гамшгийн эрсдлийг бууруулах даван туулах чадавхийг бэхжүүлэх” төсөл хэрэгжиж сургуулийн аюулгүй байдлыг хангахад чиглэгдэн хэрэгжиж байна.

ЗОРИЛГО:

Хүүхдийн бүтээлээр дамжуулан гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, хүүхдийн үзэл санааг шийдвэр гаргах түвшинд хүргэж, хүүхдэд чиглэсэн гамшгийн эрсдлийг бууруулахад нөлөөлөх.

ЗОРИЛТ:

- Гамшгийн эрсдлийг бууруулах талаар хүүхдүүдийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх.
- Хүүхдээр дамжуулан олон нийтийн гамшгийн эрсдлийн талаарх хандлагыг өөрчлөхөд нөлөөлөх.
- Хүүхдээс хүүхдэд нөлөөлөх, тэдний оролцоотойгоор сургуулийн гамшгийн эрсдэл, эмзэг байдлыг бууруулах.

ЗОХИОН БАЙГУУЛАГЧ:

- Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам
- Онцгой байдлын ерөнхий газар
- Хүүхдийн төлөө үндэсний газар
- Дэлхийн Зөн Монгол ОУБ

ХАМРАХ ХҮРЭЭ:

Монгол улсын 21 аймаг 9 дүүргийн ЕБС-ийн сурагчдын дунд дараах ангилалаар зохион байгуулагдана.

Гар зургийн уралдаан

- ✓ 6-10 нас /Бага анги/
- ✓ 11-15 нас /Дунд анги/

Эссэ бичлэгийн уралдаан

- ✓ 11-15 нас /Дунд анги/
- ✓ 16-18 нас /Ахлах анги/

БҮТЭЭЛИЙН СЭДЭВ:

Уралдаанд ирүүлэх гар зураг болон эссэ бичлэг нь дараах ерөнхий сэдвүүдийг агуулсан байж болох бөгөөд тухайн хүүхдүүдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон, чөлөөт сэтгэлгээнд үндэслэсэн, ерөнхий сэдвүүдийн хүрээнээс өөр сэдвийг хөндөөгүй бол бүтээлийн нэр сэдэв нь чөлөөтэй байж болно.

Бүтээлийн ерөнхий сэдвүүд:

- Гамшгийн эрсдлийг бууруулахад хүүхдийн оролцоо
- Сургуулийн гамшгийн эрсдлийг бууруулахад нөлөөлөх хүчин зүйлүүд
- Гамшиг онцгой байдлын үе дэх хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн асуудал
- Сургуулийн орчин дахь эрсдэл эмзэг байдал
- Бид гамшгийн эрсдлийг даван туулахад бэлэн үү?
- Гамшгийн эрсдэл сургуульд нөлөөлөх нь
- Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэлтэй гамшгийн хор уршиг
- Гамшгийн эрсдлийг бууруулах үйл ажиллагаанд олон нийт хэрхэн ханддаг вэ?

Тухайн бүтээл нь үндэсний хэмжээнд уриалга дэвшүүлсэн, шийдвэрлэхэд бэрхшээлтэй асуудлуудыг хөндсөн, бодит тоо баримтад үндэслэгдсэн шийдвэр гаргахад түвшинд нөлөөлөхөд чиглэгдсэн байж болно.

БҮТЭЭЛД ТАВИГДАХ ШААРДЛАГА:

Эссэ бичлэгийн уралдаан

- Оновчтой сэдэвтэй байна.
- Доод тал нь 400-600 үгэнд багтаасан байна.
- Arial үсгийн фонтоор 12 хэмжээтэй, мөр хоорондын зай нь 1.5, А4 бичгийн цаасанд дээр 2-4 хуудсанд багтсан байна.
- Үг үсэг болон утга найруулгын хувьд алдаагүй байх
- Бүтээлд оролцогчийн бүртгэлийн анкетыг хавсаргасан байна
- Мэдээллийн эх сурвалжийн ишлэлийг оруулсан байх

Гар зургийн уралдаан

- Бүтээл нь өөрийн гэсэн нэртэй байна
- 6-10 насны ангилалд хүүхдүүдийн бүтээл А3/297*420/-А2/420*594/ хэмжээтэй байна.

- 11-15 насны ангилалд хүүхдүүдийн бүтээл А2/420*594/-А1/594*841/ хэмжээтэй байна.
- Бүтээлийг ватум цаас болон зургийн зориулалтын цаасан дээр усан будаг, тосон харандаа /пастель/, өнгийн харандаа, гуаш /шороон будаг/ гэсэн зориулалтын хэрэгслээр зурсан байна.

АНХААРАХ ЗҮЙЛС:

- Уралдаанд нэг хүүхэд нэг бүтээлээр оролцоно.
- Хүүхэд өөрийн үзэл санаа уран сэтгэмжид тулгуурлан бүтээлээ туурвих ба ном, сурах бичиг зэрэг бусад эх үүсвэрээс хуулбарлахгүй байх.
- Оролцогчид нь уралдаанд оролцогчийн анкет бөглөж бүтээлдээ хавсаргах
- Хугацаа хоцорсон бүтээлийг аль ч шатны уралдаанд оролцуулахгүй
- Уралдаанд ирүүлсэн бүтээлүүдийг буцаан олгохгүй

УРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮЕ ШАТ:

Уралдаан нь 2 үе шаттайгаар дараах хуваарийн дагуу зохион байгуулна

Орон нутгийн түвшинд 1-р шатны уралдаан зохион байгуулагдана	Үндэсний түвшинд 2-р шатны уралдаан зохион байгуулагдана
- 2016 оны 4-р сарын 20-оос	- 2016 оны 5-р сарын 20-оос
- 2016 оны 5-р сарын 20 хүртэл	- 2016 оны 6-р сарын 10 хүртэл

ШАГНАЛЫН САН:

Орон нутгийн түвшинд зохион байгуулагдах 1-р шатны уралдаан

Эссэ бичлэгийн уралдаан:

11-15 нас:

- Нэгдүгээр байр-1 /ДЗМОУБ-ын ОНХХ-ийн нэрэмжит шагнал/
- Хоёрдугаар байр-1 /Онцгой байдлын газар/хэлтсийн нэрэмжит шагнал/
- Гуравдугаар байр-1 /Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн нэрэмжит шагнал/
- Тусгай байр-1 / Боловсрол Соёлын газрын нэрэмжит шагнал /

16-18 нас:

- Нэгдүгээр байр-1 / Боловсрол Соёлын газрын нэрэмжит шагнал /
- Хоёрдугаар байр-1 /ДЗМОУБ-ын ОНХХ-ийн нэрэмжит шагнал/
- Гуравдугаар байр-1 /Онцгой байдлын газар/хэлтсийн нэрэмжит шагнал/
- Тусгай байр-1 /Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн нэрэмжит шагнал/

Гар зургийн уралдаан:

6-10 нас:

- Нэгдүгээр байр-1 /Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн нэрэмжит шагнал/
- Хоёрдугаар байр-1 / Боловсрол Соёлын газрын нэрэмжит шагнал /
- Гуравдугаар байр-1 /ДЗМОУБ-ын ОНХХ-ийн нэрэмжит шагнал/
- Тусгай байр-1 /Онцгой байдлын газар/хэлтсийн нэрэмжит шагнал/

11-15 нас

- Нэгдүгээр байр-1 /Онцгой байдлын газар/хэлтсийн нэрэмжит шагнал/
- Хоёрдугаар байр-1 /Хүүхэд гэр бүлийн хөгжлийн хэлтсийн нэрэмжит шагнал/
- Гуравдугаар байр-1 / Боловсрол Соёлын газрын нэрэмжит шагнал /
- Тусгай байр-1 /ДЗМОУБ-ын ОНХХ-ийн нэрэмжит шагнал/

Жич: Шилдэг бүтээлүүдийн өргөмжлөл болон сурталчилгааны хэвлэмэл материалууд нь ДЗМОУБ-ын "Сургуулийн гамшгийн эрсдлийг бууруулах даван туулах чадавхийг бэхжүүлэх төсөл"-с нэгдсэн байдлаар хэвлэгдэн хүргэгдэнэ.

Үндэсний хэмжээнд зохион байгуулагдах 2-р шатны уралдаан

Эссэ бичлэгийн уралдаан:

11-15 нас:

- Гранпри нэгдүгээр байр-1 хүүхэд /Найрамдал зусланд амрах эрхийн бичиг, 150,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Дэд байр-2 хүүхэд /100,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Гутгаар байр-3 хүүхэд /80,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Тусгай байр-4 хүүхэд /50,000 төгрөгний үнэ бүхий зүйл/

16-18 нас:

- Гранпри нэгдүгээр байр-1 хүүхэд /Найрамдалд амрах эрхийн бичиг, 200,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Дэд байр-2 хүүхэд /150,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Гутгаар байр-3 хүүхэд /100,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Тусгай байр-4 хүүхэд /80,000 төгрөгний үнэ бүхий зүйл/

Гар зургийн уралдаан:

6-10 нас:

- Гранпри нэгдүгээр байр-1 хүүхэд /Найрамдал зуслан амрах эрхийн бичиг, 150,00 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Дэд байр-2 хүүхэд /100,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Гутгаар байр-3 хүүхэд /80,000 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Тусгай байр 4 хүүхэд /50,000төгрөгний үнэ бүхий зүйл/

11-15 нас

- Гранпри нэгдүгээр байр-1 хүүхэд /Найрамдал зуслан амрах эрхийн бичиг, 200,00 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Дэд байр-2 хүүхэд /Найрамдал зуслан амрах эрхийн бичиг, 150,00 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Гутгаар байр-3 хүүхэд /Найрамдал зуслан амрах эрхийн бичиг, 100,00 төгрөгний үнэ бүхий зүйл/
- Тусгай байр-4 хүүхэд /Найрамдал зуслан амрах эрхийн бичиг, 80,00 төгрөгний үнэ бүхий зүйл/

Жич: Уралдаан зохион байгуулах комисс байгуулах, шалгаруулах журам, оролцогчийн бүртгэлийн анкет зэргийг хавсралтаар хүргүүлэв.